Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна

Тус төвийн 2024 оны үйл ажиллагаанд НЭМГ-ын дотоод аудит, мониторингийн газраас хяналт шалгалт хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Нийслэлийн Түргэн тусламжийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус төв Нийслэлийн Түргэн тусламжийн төвийн 2020 оны А/21 дүгээр тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Нийслэлийн Түргэн тусламжийн төвийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,435,150.8 мянган төгрөгөөр буюу 7.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 2,619.9 | 654,875.6 | 652,255.7 |
| Авлага | 4,264,795.4 | 5,292,313.8 | 1,027,518.4 |
| Бараа материал | 1,221,522.6 | 1,248,946.0 | 27,423.4 |
| Үндсэн хөрөнгө | 13,531,998.5 | 13,259,951.8 | (272,046.7) |
| **Нийт хөрөнгө** | **19,020,936.4** | **20,456,087.2** | **1,435,150.8** |
| Өр төлбөр | 613,434.5 | 1,335,984.5 | 722,550.0 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 18,407,501.9 | 19,120,102.7 | 712,600.8 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **19,020,936.4** | **20,456,087.2** | **1,435,150.8** |

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс дараах данснуудад нөлөө бүхий өөрчлөлтүүд гарсан байна. Үүнд:

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 654,875.6 мянган төгрөг болж 652,255.7 мянган төгрөгөөр өссөн нь жилийн эцэст санхүүжилт орж ирсэнтэй холбоотой байна.

Авлага дансны үлдэгдэл 5,292,313.8 мянган төгрөг болж 1,027,518.4 мянган төгрөгөөр өссөн нь төлбөртэй үйлчилгээний авлага нэмэгдсэнтэй холбоотой байна.

Бараа материал дансны үлдэгдэл 1,248,946.0 мянган төгрөг болж 27,423.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 3,689,196.5 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, НЭМГ-ын даргын А/26, А/27, А/28 тушаалуудаар нийт 122,575.3 мянган төгрөгийн бараа материал хүлээн авч, 3,460,339.8 мянган төгрөгийн материал зарцуулж, 312,288.9 мянган төгрөгийн материал акталж данснаас хасч, дутагдуулсан 11,719.7 мянган төгрөгийн материалыг данснаас хасч төлүүлсэнтэй тус тус холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 13,259,951.8 мянган төгрөгт хүрч 272,046.7 мянган төгрөгөөр буурсан нь 595,167.6 мянган төгрөгөөр автобаазын барилгад их засвар хийсэн, НЭМГ-ын нийлүүлсэн 238,800.0 мянган төгрөгийн 2 автомашин, 78,000.0 мянган төгрөгийн эмнэлэгийн тоног төхөөрөмжийг хүлээн авсан, төвийн захирлын тушаалаар 30,682.9 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 25,855.4 мянган төгрөгийн тавилга эд хогшил худалдан авч, НӨХГ-ын даргын А/100 тоот тушаалаар 497,343.6 мянган төгрөгийн машин тоног төхөөрмж, тавилга эд хогшил, программ хангамжийг, А/113, А/803 тоот тушаалуудаар 621,401.0 мянган төгрөгийн 14 автомашиныг акталж данснаас хассан, НЗД-ын А/681 тоот захирамжаар 70,416.0 мянган төгрөгийн автомашиныг балансаас балансад шилжүүлсэн, 1,240,552.7 мянган төгрөгийн элэгдлийг тайлант онд байгуулсан, данснаас хасагдсан хөрөнгүүдийн 1,189,160.7 мянган төгрөгийн элэгдэл хасагдсантай тус тус холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 1,335,984.5 мянган төгрөгт хүрч 722,550.0 мянган төгрөгөөр өссөн нь нийгмийн даатгалын шимтгэлийн 721,647.6 мянган төгрөг, хувь хүний орлогын албан татварын 529,448.4 мянган төгрөг, 84,888.5 мянган төгрөгийн бараа ажил үйлчилгээний өглөгийг төлөөгүйтэй тус тус холбоотой байна.

Эздийн өмчийн дүн 722,550.0 мянган төгрөгт хүрч 712,600.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант оны үр дүн 712,600.8 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг эрүүл мэндийн даатгалын сангаас 19,624,200.0 мянган төгрөг, нийт зарлагыг 19,624,200.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 3,898,049.5 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 623,303.0 мянган төгрөг, Хангамж, бараа материалын зардлыг 332,473.6 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 77,957.0 мянган төгрөг, хөрөнгийн зардлыг 141,974.0 мянган төгрөгөөр тус тус бууруулж, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 29,192.9 мянган төгрөг, нормативт зардлыг 79,997.4 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардлыг

908,323.5 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 347,659.9 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлыг 30,000.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих 15,854,877.0 мянган төгрөг, төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас 90,739.6 мянган төгрөгийг бүрдүүлэхээр баталсан байна.

Тайлант оны батлагдсан төсвийг 5,707,724.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 21,264,690.1 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас, төсөвт байгууллагын ажил үйлчилгээний орлогоос 388,650,9 мянган төгрөөр, нийт 21,653,341.0 мянган төгрөг бүрдүүлэхээр батлагдсан.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр эрүүл мэндийн даатгалаас 19,969,560.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагааны орлого 412,817.3 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 19,730,121.6 мянган төгрөг буюу 91.1 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 1,647,546.9 мянга, ажил олгогчоос олгох тэтгэмжийн зардлыг 2,021.8 мянга, Нэмэлт-Дээд шатны төсвөөс хуваарилсан зардлын төсвийг 354,010.4 мянган төгрөгөөр тус тус дутуу, харуул хамгаалалтын зардлын төсвийг 80,359.7 мянган төгрөгөөр илүү зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| **1** | **71601 Нийгмийн эрүүл мэнд** | **21,653,341.0** | **19,730,121.6** | **1,923,219.4** | 91.1 |
| 1.1 | 80101-Үндсэн үйл ажиллагааны зардал | 19,478,921.3 | 17,831,374.4 | 1,647,546.9 | 91.5 |
| 1.2 | 80219- Харуул хамгаалалтын зардал | 9,450.0 | 89,809.7 | (80,359.7) | 950.4 |
| 1.3 | 80802- Ажил олгогчоос олгох тэтгэмж | 472,021.8 | 470,000.0 | 2,021.8 | 99.6 |
| 1.4 | 83602-ЗГ болон ЗД-ын нөөц хөрөнгөөс хуваарилсан | 112,359.8 | 112,359.8 | - | 100.0 |
| 1.5 | 83603-Нэмэлт-Дээд шатны төсвөөс хуваарилсан | 1,580,588.1 | 1,226,577.7 | 354,010.4 | 77.6 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 4,763,222.7 мянган төгрөг, харьцуулалтын аргаар 246,592.6 мянган төгрөг, өрөнхий гэрээний аргаар 98,276.6 мянган төгрөг, нийт 5,108,090.8 мянган төгрөгийн худалдан авалт хийхээр төлөвлөсөн байна. Үүнээс 4,289,814.8 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхийн худалдан авалтыг журмын дагуу зарлаж, 4,106,715.0 мянган төгрөгийн худалдан авалт хийж, санхүүжилт дутуу орж ирснээс 818,276.0 мянган төгрөгийн худалдан авалтын тендерийг зарлаагүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Нийслэлийн Түргэн тусламжийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, худалдан авах ажиллагааг хуульд нийцүүлэн зохион байгуулах, хэрэгцээ шаардлагагүй бараа материал нөөцлөхгүй байхтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Аккаунт траст аудит ХХК-ийн ахлах аудитор Ч.Замбага, аудитор Р.Цогзолмаа, туслах аудитор П.Саранчимэг нар гүйцэтгэж, анхан шатны хяналтыг чанарын хяналтын менежер Д.Эрдэнэтуяа, захирал П.Наранцэцэг нар, дараагийн шатны хяналтыг НТАГ-ын Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн аудитын менежер С.Гантөгс, хэлтсийн дарга Х.Түвшинбаяр, дэд дарга Ч.Болд нар тус тус хэрэгжүүлсэн.

Нийслэлийн Түргэн тусламжийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Нийслэл дэх Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн ОБ/55 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны нийт зардлын 17,438,318.3 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 174,383.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хязгаарлалт, хэмнэлтийн горимыг баримтлан ажиллаж нэмэгдэл урамшууллын зардлыг 442,819.1 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 17,583.7 мянган төгрөг, бараа үйлчилгээний урсгал зардлыг 417,455.1 мянган төгрөгөөр тус тус хэмнэлттэй зарцуулсан байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх

дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлбэл зохих мэдээллүүдийг цаг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

**Худалдан авалтын гэрээний үүргийн гүйцэтгэлтэй холбоотой асуудал**

Түргэн тусламжийн дуудлагын тоо өмнөх оноос 2 дахин нэмэгдсний улмаас өдөрт гарч байгаа дуудлагын автомашины тоо хүрэлцэхгүй, эвдрэл гэмтэлтэй, гүйлтийн норм дуссан автомашинууд дуудлагад үйлчилснээс хүлээгдэл үүсэж, иргэдийн эрүүл мэнд, амь насанд хохирол учрах эрсдэл үүссэн тул Хьюндэй Старикс маркийн 6 ширхэг автомашины засвар үйлчилгээг албан ёсны баталгаатай, сэлбэг засвар үйлчилгээний газар болох Монгол Хьюндэй Автомотив ХХК-аар гүйцэтгүүлснээс бараа, ажил үйлчилгээ нийлүүлэх гэрээний үнийн дүнгээс 352,159.5 мянган төгрөгөөр хэтрүүлэн худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2-д "Худалдан авах гэрээ болон ерөнхий гэрээний үүргийн гүйцэтгэлийн явцад дараах зүйлийг хориглоно: 40.2.1.энэ хуулийн 40.1-д зааснаас бусад үндэслэлээр гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах;" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн шаардлага хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын үйл ажиллагааны онцлогыг харгалзан худалдан авах ажиллагааг төлөвлөж, хуульд нийцүүлэн худалдан авах ажиллагааг зохион байгуулах албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, Худалдан авах гэрээний үүргийн гүйцэтгэлтэй холбогдох асуудал нь худалдан авах ажиллагааны хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

## 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

### 4.5.1 Завсрын аудитын талаар

Нийслэлийн Түргэн тусламжийн төвийн 2024 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд завсрын аудит хийж, илрүүлсэн 5,879,444.6 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг асуудлын бүртгэлээр танилцуулж, 4 залруулга, 3 зөвлөмж, 2 албан шаардлага хүргүүлэх саналыг асуудлын бүртгэлээр танилцуулж баталгаажуулсан.

Биелэлтийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянаж, залруулах боломжгүй 2 зөрчлийг аудитын тайланд тусгалаа.

### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 291,040.1 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгснийг 66.7 хувь хэрэгжүүлсэн байна.

*Хүснэгт 4* Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Зөвлөмж | 3 | 291,040.1 | 2 | 291,040.1 | 66.7 |
| Нийт дүн | 3 | 291,040.1 | 2 | 291,040.1 | 66.7 |

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгүүдийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох талаар холбогдох саналыг бэлтгэн Нийслэлийн өмчийн харилцааны газарт хүргүүлсэн боловч шийдвэр гараагүйгээс 1 зөвлөмж хэрэгжээгүй байна.

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгүүдийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоосон эсэхийг авч үзэх

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 257,159.8 мянган төгрөгийн алдаа[1] илэрснийг аудитын явцад залрууллаа.

*Залруулсан алдаа:*

- Үр дүнгийн тайланд цалингийн зардал 257,159.8 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнасан нь УСНББОУС1-3.2 "Улсын секторын байгууллагуудын Нийтлэг зориулалттай санхүүгийн тайланд тусгах мэдээллийн чанарын шинжүүд нь хамааралтай байх, үнэн зөв илэрхийлэх, ойлгомжтой байх, цаг хугацаандаа байх, зэрэгцүүлэгдэх боломжтой байх, шалгах боломжтой байх гэсэн шинжүүд юм" гэж заасантай нийцээгүй, үнэн зөв байх, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 67,100.0 мянган төгрөгийн зөрчил[2] илэрснээс 61,400.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, 5,700.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**5.2 Албан шаардлага**

**1. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал**

Тайлант онд бараа, ажил үйлчилгээний 61,400.0 мянган төгрөгийн худалдан авалтыг 2 аж ахуйн нэгжээс шууд гэрээгээр гүйцэтгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4-т "хуульд өөрөөр заагаагүй бол бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох", 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил,үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-т "Захиалагч ерөнхий гэрээний аргаар худалдан авахаас бусад тохиолдолд хуульд заасан төсөвт өртөгт үндэслэн тендер шалгаруулалтын дараах аргын аль нэгийн дагуу зохион байгуулна", Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар"-тай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн шаардлага хангаагүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь</u>: Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага өгөв.

**5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**1. 2.Бараа материалын нөөцтэй холбоотой асуудал**

*<u>Илрүүлэлт:</u>*

Тайлант онд хэрэгцээ шаардлагагүй 5,700.0 мянган төгрөгийн 3 нэрийн бараа материал худалдан авч, нөөцлөн бараа материалын дансны үлдэгдлийг нэмэгдүүлсэн байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх;" , Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

*<u>Өгсөн зөвлөмж:</u>*

Төсвийн хөрөнгийг зөв удирдах, хэрэгцээ шаардлагагүй бараа материал нөөцлөхгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 08 дүгээр сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Үр дүнгийн тайланд цалингийн зардал 257,159.8 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнагдсан байна | 1 | 257,159.8 | - | - | 1 | 257,159.8 | 1 | 257,159.8 | - | - | - | - |
| Дүн | 1 | 257,159.8 | - | - | 1 | 257,159.8 | 1 | 257,159.8 | - | - | - | - |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Тайлант онд хэрэгцээ шаардлагагүй 5,700.0 мянган төгрөгийн 3 нэрийн бараа материал худалдан авч, нөөцлөн бараа материалын дансны үлдэгдлийг нэмэгдүүлсэн байна | 1 | 5,700.0 | - | - | - | - | 1 | 5,700.0 | - | - | - | - |
| Тайлант онд бараа, ажил үйлчилгээний 61,400.0 мянган төгрөгийн худалдан авалтыг 2 аж ахуйн нэгжээс шууд гэрээгээр гүйцэтгэсэн байна. | 1 | 61,400.0 | | | 1 | 61,400.0 | - | - | - | - | - | - |
| **Дүн** | **2** | **67,100.0** | - | - | **1** | **61,400.0** | **1** | **5,700.0** | - | - | - | - |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| **Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил** | | | | | | | | |
| | | | | | | | | |
| **Бусад хууль тогтоомжтой холбоотой** | | | | | | | | |
| Түргэн тусламжийн дуудлагын тоо өмнөх оноос 2 дахин нэмэгдсний улмаас өдөрт гарч байгаа дуудлагын автомашины тоо хүрэлцэхгүй, эвдрэл гэмтэлтэй, гүйлтийн норм дуссан автомашинууд дуудлагад үйлчилснээс хүлээгдэл үүсэж, иргэдийн эрүүл мэнд, амь насанд хохирол учрах эрсдэл үүссэн тул Хьюндэй Старикс маркийн 6 ширхэг автомашины засвар үйлчилгээг албан ёсны баталгаатай, сэлбэг засвар үйлчилгээний газар болох Монгол Хьюндэй Автомотив ХХК-аар гүйцэтгүүлснээс бараа, ажил үйлчилгээ нийлүүлэх гэрээний үнийн дүнгээс 352,159.5 мянган төгрөгөөр хэтрүүлэн худалдан авалт хийсэн байна | 1 | 352,159.5 | | | 1 | 352,159.5 | - | - |
| **Дүн** | **1** | **352,159.50** | **-** | **-** | **1** | **352,159.50** | **-** | **-** |

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2025 оны 02 сарын 25 өдөр Дугаар 35/10310474 Улаанбаатар хот

НТАГ - 2025/156/НА-СТА - ТШ3

## Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн түргэн тусламжийн төвийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Засгийн газрын "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" 2024 оны 02 дугаар тогтоолоор баталсан төсөвт өртгийн дээд хязгаараас давсан 61,400,000.00 (жаран нэгэн сая дөрвөн зуун мянган) төгрөгийн худалдан авалтыг 2 аж ахуйн нэгжээс шууд худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т *"Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хуваах худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно."*, 31 дүгээр зүйлийн 31.1-т *"Захиалагч ерөнхий гэрээний аргаар худалдан авахаас бусад тохиолдолд хуульд заасан төсөвт өртөгт үндэслэн тендер шалгаруулалтын дараах аргын аль нэгийн дагуу зохион байгуулна:..."* гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т *"Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө"*, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.9-д *Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол;"* заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Худалдан авах ажиллагааг холбогдох хуулийн дагуу зохион байгуулаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Нийслэл дэх төрийн аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн түргэн тусламжийн төвийн дарга С.Ариунболд, ахлах нягтлан бодогч Б.Сэргэлэн нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН[1]:**

АККАУНТ ТРАСТ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ П.НАРАНЦЭЦЭГ

ХЯНАСАН:

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ХЭЛТСИЙН АУДИТЫН МЕНЕЖЕР С.ГАНТӨГС

1117145633
УХА0612 9077278

[1] Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 4 давхар

02643300

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2025 оны 02 сарын 05 өдөр Дугаар 35/1031ө474 Улаанбаатар хот
НТАГ-2025/156/НА-СТА-ТШЗ

# Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн түргэн тусламжийн төвийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нээлттэй тендер шалгаруулалтаар худалдан авсан барааны анхны гэрээний үнийн дүнгээс 352,159,500.00 (гурван зуун тавин хоёр сая нэг зуун тавин есөн мянган таван зуун) төгрөгийн илүү худалдан авалтыг 1 аж ахуйн нэгжээс хийсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2-т "*Худалдан авах гэрээ болон ерөнхий гэрээний үүргийн гүйцэтгэлийн явцад дараах зүйлийг хориглоно:*", 40.2.1-д "*энэ хуулийн 40.1-т зааснаас бусад үндэслэлээр гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах;*" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.9-д *Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол;*" заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Худалдан авах гэрээний үүргийн гүйцэтгэлийн явцад нэмэлт өөрчлөлт оруулсан зөрчлийг арилгаж, биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Нийслэл дэх төрийн аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн түргэн тусламжийн төвийн дарга С.Ариунболд, ахлах нягтлан бодогч Б.Сэргэлэн нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН[1]:**

АККАУНТ ТРАСТ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ П.НАРАНЦЭЦЭГ

ХЯНАСАН:

САНХҮҮ,НИЙЦЛИЙН АУДИТЫН ХЭЛТСИЙН АУДИТЫН МЕНЕЖЕР С.ГАНТӨГС

1117145633
УХА0612 9077278

[1] Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 4 давхар

02643326